



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 5/аг

Хажуу шинэ ус

Түр орлон гүйцэтгэгч томилж, ажил
хүлээлцэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05/227 тоот хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын эрүүл мэндийн төвийн дарга Галхүүгийн Энхдэлгэр нь 2021 оны 11 дүгээр сарын 23-наас эхлэн жирэмсний амралтаа авч байгаа тул үүрэгт ажлыг Дотрын их эмч Нямсүрэнгийн Долгорсүрэнд хавсран түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Г. Энхдэлгэрээс Н. Долгорсүрэнд ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын ахлагч

Д. Сарангэрэл (Засаг даргын орлогч)

Гишүүдэд

Б. Саруултамир (Эрүүл мэндийн төвийн нярав)

Б. Батцэнгэл (Нягтлан бодогч)

3. Ажил хүлээлцэх акт үйлдэн гарын үсгээр баталгаажуулж, хариуцлагатай хүлээлцэхийг комиссын дарга (Д. Сарангэрэл)-д даалгасугай.

4. Албан тушаалын чиг үүргийн дагуу эрхэлсэн ажилдаа хариуцлага санаачлагатай хандан төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н. Долгорсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн төвийн даргын үндсэн цалингийн 40% болох 330,209 (Гурван зуун гучин мянга хоёр зуун ес) төгрөгөөр тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Б. Батцэнгэл)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ө. МӨНХ-АМГАЛАН

